



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/186/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он

Дарга,
тэргүүлэх аудитор:
Утас: 99993365

Д.Бат-Ундраа
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер:
Утас: 99105506

Х.Болдбаатар
Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитор:
Утас: 88161818

Л.Гансүлд
Цахим хаяг: gansuldl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

Завх. А. 23 № 258

танай _____ -ны № _____ -т

ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГА Х.ОНОЛБААТАР-Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд улсын төсвөөс 364.3 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны орлогоос 15.8 сая төгрөгийн, нийт 380.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэн зарцуулж, 78 тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажилласан байна.

Аудитын гол асуудал

2024 оны завсрын үеийн санхүүгийн аудитаар албан хаагчдад илүү цагийн нэмэгдлийг олгохдоо Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолыг баримтлаагүй, илүү тооцож олгосон зөрчил илэрсэн бөгөөд уг зөрчлийн хүрээнд албан шаардлага хүргүүлэн албан хаагчдаас суутгаж зөрчлийг арилгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А-3 сургалтыг зохион байгуулах талаар 24 сумаас иргэдийн бүртгэлийг хийж "Худалдан авах үйл ажиллагааны хөтөч" ТББ-тай хамтран сургалтыг зохион байгуулсан бөгөөд 140 хүн сургалтад хамрагдсанаас 78 хүн тэнцэж А-3 сертификат авсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/disk/Албан бичиг/Дүгнэлт

81 5 2452

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,729,350.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,729,350.00
354	Хангамжийн материал	3,729,350.00
35410	Бичиг хэргийн материал	2,403,000.00
35420	Аж ахуйн материал	86,350.00
35440	Түлш, шатах тослох материал	280,000.00
35450	Барилгын засварын материал	960,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	48,386,954.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	48,386,954.18
392	Биет хөрөнгө	47,111,954.18
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	35,525,790.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,989,689.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,042,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,466,645.87)
393	Биет бус хөрөнгө	1,275,000.00
39301	Програм хангамж	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(225,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	52,116,304.18
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	229,706.86
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	229,706.86
413	Өглөг	229,706.86
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	229,706.86
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	51,886,597.32
51	Засгийн газрын хувь оролцоо	51,886,597.32
512	Хуримтлагдсан үр дүн	51,886,597.32
51220	Тайлант үеийн үр дүн	51,886,597.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	52,116,304.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	435,212,458.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,870,158.77
120	Нийтлэг татварын бус орлого	70,870,158.77
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,870,158.77
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,822,976.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	55,047,182.77
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	364,342,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	364,342,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	364,342,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	383,325,861.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	383,325,861.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	365,045,068.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	277,339,349.93
210101	Үндсэн цалин	143,138,528.03
210102	Нэмэгдэл	89,461,138.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,592,545.45
210104	Урамшуулал	19,147,138.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,986,816.83
210201	Тэтгэврийн даатгал	23,821,328.09
210202	Тэтгэмжийн даатгал	2,773,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,737,136.14
210204	Ажилгүйдлийн даатгал	894,352.60
210205	Эрүүл мэндийн даатгал	4,761,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	13,509,346.64
210401	Бичиг хэрэг	6,865,750.00
210402	Тээвэр, шатахуун	3,605,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,038,396.64
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,640,000.00
210604	Урсгал засвар	9,640,000.00
2107	Томилолт, зочны зардал	14,590,000.00
210702	Дотоод албан томилолт	14,590,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,334,327.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,822,827.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	511,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,645,228.59
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,645,228.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,280,792.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,868,976.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,868,976.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,411,816.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,411,816.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	51,886,597.32
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	51,886,597.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	380,165,276.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,822,976.00
120	Нийтлэг татварын бус орлого	15,822,976.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,822,976.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,822,976.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	364,342,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	364,342,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	364,342,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	377,180,276.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	377,180,276.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	358,899,483.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	277,109,643.07
210101	Үндсэн цалин	142,908,821.17
210102	Нэмэгдэл	89,461,138.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,592,545.45
210104	Урамшуулал	19,147,138.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,986,816.83
210201	Тэтгэврийн даатгал	23,821,328.09
210202	Тэтгэмжийн даатгал	2,773,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,737,136.14
210204	Ажилгүйдлийн даатгал	894,352.60
210205	Эрүүл мэндийн даатгал	4,761,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,278,696.64

210401	Бичиг хэрэг	9,268,750.00
210402	Тээвэр, шатахуун	3,885,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,038,396.64
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	86,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,600,000.00
210604	Урсгал засвар	10,600,000.00
2107	Томилолт, зочны зардал	14,590,000.00
210702	Дотоод албан томилолт	14,590,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,334,327.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,822,827.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	511,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,280,792.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,868,976.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,868,976.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,411,816.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,411,816.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,985,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,985,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,985,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,985,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,985,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,985,000.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
6	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
8	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	51,886,597.32	51,886,597.32
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	51,886,597.32	51,886,597.32

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	364,341,200.00	363,213,506.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	364,341,200.00	363,213,506.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	353,095,200.00	351,967,506.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	277,371,800.00	277,109,643.07

210101	Үндсэн цалин	146,030,800.00	142,908,821.17
210102	Нэмэгдэл	94,683,600.00	89,461,138.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,520,000.00	25,592,545.45
210104	Урамшуулал	22,137,400.00	19,147,138.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,671,500.00	33,986,816.83
210201	Тэтгэврийн даатгал	23,576,600.00	23,821,328.09
210202	Тэтгэмжийн даатгал	2,773,700.00	2,773,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,386,900.00	1,737,136.14
210204	Ажилгүйдлийн даатгал	1,386,900.00	894,352.60
210205	Эрүүл мэндийн даатгал	5,547,400.00	4,761,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,719,600.00	13,669,546.64
210401	Бичиг хэрэг	5,256,800.00	6,745,950.00
210402	Тээвэр, шатахуун	3,885,200.00	3,885,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,577,600.00	3,038,396.64
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,600,000.00	10,600,000.00
210604	Урсгал засвар	10,600,000.00	10,600,000.00
2107	Томилолт, зочны зардал	14,720,800.00	14,590,000.00
210702	Дотоод албан томилолт	14,720,800.00	14,590,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,011,500.00	2,011,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,011,500.00	2,011,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,246,000.00	11,246,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,246,000.00	11,246,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11,246,000.00	11,246,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	364,341,200.00	363,213,506.54
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	364,341,200.00	363,213,506.54
122005	Орон нутгийн төсвөөс	364,341,200.00	363,213,506.54

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,539,953.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,539,953.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,916,977.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,609,150.00
210401	Бичиг хэрэг	2,522,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	86,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,485,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,485,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,822,827.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,822,827.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,622,976.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,622,976.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,622,976.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

2024 оны Худалдан авах ажиллагааны газрын төлөвлөгөөнд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 97 төсөл арга хэмжээний тендер шалгаруулах ажлыг зохион байгуулахаар батлуулж 78 тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажилласан байна.

Тус байгууллага нь Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А-3 сургалтыг зохион байгуулах талаар 24 сумаас иргэдийн бүртгэлийг хийж “Худалдан авах үйл ажиллагааны хөтөч” ТББ-тай хамтран сургалтыг зохион байгуулсан бөгөөд 140 хүн сургалтад хамрагдсанаас 78 хүн тэнцэж А-3 сертификат авсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Худалдан авах ажиллагааны газар нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Худалдан авах ажиллагааны газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Худалдан авах ажиллагааны газар нь 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал		3,729.30	3,729.30
Үндсэн хөрөнгө		48,386.95	48,386.95
Нийт хөрөнгө		52,116.30	52,116.30
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/		51,886.59	51,886.59
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн		52,116.30	52,116.30

Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 25-ны А/482 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг “Худалдан авах ажиллагааны газар”-ыг байгуулсан байна.

Орон нутгийн өмчийн газраас худалдан авах ажиллагаа хариуцсан албан хаагчдыг цалингийн сан, эд хөрөнгийн хамт шилжүүлэн ажиллуулжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 364.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 364.3 сая төгрөгийн санхүүжилт баталж, 1.1 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, гүйцэтгэл 99.69 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал (80101)	353,095.20	351,967.50	1,127.7	99.68
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг (80802)	11,246.00	11,246.00		100
	Бүгд	364,341.20	363,213.50	1,128.79	99.69

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр 15.8 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд:

- Үйлчилгээний хураамжийн орлого 4.8 сая төгрөг
- Төрийн албанд тасралтгүй ажилласан 5 жилийн мөнгөн урамшуулал 4.6 сая төгрөг
- ТББ-н үнэ 6.3 сая төгрөг

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тусгайлан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Гансүлд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн нийт орлогоор сонгож 262.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн нийт орлого 435.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.5 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Худалдан авах ажиллагааны газар нь шилэн дансны мэдээллийг анхан шатны баримттай тулган шалгахад алдаа зөрчил илрээгүй болно.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хийж гүйцэтгэсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Завсрын аудитаар албан хаагчдад илүү цагийн нэмэгдлийг илүү тооцож олгосон зөрчил илэрсэн бөгөөд уг зөрчлийн хүрээнд илүү тооцож олгосон 1,947,320.23 төгрөгийг албан хаагчдаас суутгуулахаар албан шаардлага хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	1,947,320.23	1	1,947,320.23	100
Зөвлөмж					
Нийт дүн	1	1,947,320.23	1	1,947,320.23	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2.0 сая төгрөгийн зөрчил илэрч зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх зөрчил илрээгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой

1.1 Илрүүлэлт: Эрх бүхий албан тушаалтны нэмэгдлийг батлагдсан төсвийн хүрээнд олгоогүй, 40 хувиар тооцож, 2,067,714.00 төгрөгийг илүү олгосон зөрчил байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2-т “бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрх бүхий албан тушаалтны нэмэгдлийг батлагдсан төсвийн хүрээнд 20 хувиар тооцож олгох

Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу гарган зөвлөмж хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

Зөвлөмжийн биелэлтийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэн 2025 оны 04 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй			
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрх бүхий албан тушаалтны нэмэгдлийг батлагдсан төсвийн хүрээнд олгоогүй	1	2,067.7					1	2,067.7				
Дүн	1	2,067.7					1	2,067.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Үүнээс				/мянган төгрөгөөр/	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										

БОЛОВСРУУЛСАН : АУДИТОР

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АУДИТЫН МЕНЕЖЕР

2025.02.20

2025.02.20

2025.02.20

